



ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМ  
ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН  
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 154/ЗТ2025/00001

Бүрэнхайрхан

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМ ДАХЬ СУМ  
ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН  
ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ

Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах,  
хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч,  
шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам батлах тухай

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр  
Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг,  
маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох  
журам батлах тухай хэлэлцээд

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр  
зүйлийн 19.1, 19.2, 19.2.5, 19.8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2  
дугаар зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 6, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх  
тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлд заасныг тус тус удирдлага  
болгон

ТОГТООХ нь:

- Хэрэг хуваарилах шүүгчдийн нэрсийн дарааллыг тогтоох
  - Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, санал, дүгнэлт хүлээн  
авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх хуралдаан даргалагчийн  
дарааллыг сугалаагаар томилогдсон дарааллаар нэгдсэн системд дор дурдсанаар  
байршуулсугай.
  - Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүгчийн дарааллыг  
сугалаагаар Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд
    - Шүүгч Ц.Энхжаргал
    - Ерөнхий шүүгч Б.Бадрахгэрэл
    - Шүүгч Л.Түвшинжаргал гэсэн дарааллаар байршуулж, тойрог үүсгэх
  - Иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүгчийн дарааллыг сугалаагаар “Иргэн-2014” нэгдсэн системд

1. Шүүгч Ц.Энхжаргал
2. Ерөнхий шүүгч Б.Бадрахгэрэл
3. Шүүгч Л.Түвшинжаргал гэсэн дарааллаар байршуулж, тойрог үүсгэх
  - 1.4. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системд тус тус байршуулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэн О.Хүрэлбаатарт даалгасугай.
2. Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох
  - 2.1. Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох дарааллыг системд байршуулахдаа сугалаагаар томилогдсон дарааллын дагуу дор дурдсанаар тогтоосугай.
  - 2.2. Шүүх бүрэлдэхүүнд шүүгч Ц.Энхжаргал, Ерөнхий шүүгч Б.Бадрахгэрэл, шүүгч Л.Түвшинжаргал нарыг оролцуулахаар тогтоосугай.
  - 2.3. Хэргийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх тохиолдолд тухайн хэрэг хуваарилагдсан шүүгчээр шүүх хуралдааныг даргалуулсугай.
  - 2.4.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд харьялах аймаг нийслэлийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр болон адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцэж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар тогтоосугай.
- 2.5. Адил шатны өөр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг томилохдоо тус тогтоолын 1.1, 1.2-т заасан дарааллаар бүрэлдэхүүнд орох, тухайн шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд дараагийн шүүгч бүрэлдэхүүнд томилуулан оролцуулсугай.
3. Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилах журмыг нэгдүгээр хавсралтаар, иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Шүүх хуралдааныг даргалах болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллын дагуу Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системээс хуваарилсныг Ерөнхий шүүгч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т зааснаар захирамж гарган албажуулсугай.
5. Уг тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий шүүгч, зохион

байгуулалт, биелэлтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга нарт тус тус даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01 дугаартай тогтоолыг хүчингүйд тооцсугай.

7. Энэхүү тогтоолыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Шүүгчдийн зөвлөгөөний 2024 оны 12 дугаар  
сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолын  
нэгдүгээр хавсралт

ШҮҮХЭД ЭРҮҮГИЙН БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ,  
САНАЛ, ДҮГНЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ  
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР  
ТОМИЛОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хуваарилах, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Шүүхэд хүлээн авч байгаа хэрэг, өргөдөл, гомдол, эсэргүүцэл, хүсэлт, санал, дүгнэлтийг Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ажлын цагт “Прокуророос шилжүүлсэн эрүүгийн хэргийг хүлээн авсан бүртгэл”, “Прокуророос шилжүүлсэн зөрчлийн хэрэг, оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлт хүлээн авсан бүртгэл”, “Анхан шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл, өргөдөл, хүсэлт хүлээн авсан бүртгэл”, “Зөрчлийн хэрэгт давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл, өргөдөл, хүсэлт хүлээн авсан бүртгэл”-ийн дагуу шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийнэ.

1.3. Таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг уг асуудлыг шийдвэрлэх тухайн шүүгчийн туслах хүлээн авч, ирсэн цаг минутын дарааллаар тэмдэглэгээ хийж шүүгчид хүлээлгэж өгнө. Тухайн шүүгч нэгдсэн системд өөрийн эрхээр нэвтрэн, санал, хүсэлт, гомдлыг бүртгэж авна.

1.4. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудал болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүгчийн зөвшөөрлөөр хийгдэх ажиллагааг шүүгч Л.Түвшинжаргал шийдвэрлэнэ. Ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, томилолттой гэх мэт бусад хүндэтгэн үзэх шалтааны улмаас тухайн шүүгч эзгүй байгаа үед шүүгч Ц.Энхжаргал, Ерөнхий шүүгчээс бусад шүүгчид эзгүй тохиолдолд Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

Хоёр. Эрүүгийн хэрэг хуваарилах

2.1. Шүүхэд ирсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс сугалаагаар тогтоосон тойрог дотор санамсаргүй тохиолдлын зарчмаар доорх 2 аргаар хуваарилна.

а. "Ердийн журмаар хэрэг хуваарилах арга"-аар олон хавтас бүхий, олон оролцогчтой хэргээс бусад бүх хэргийг хуваарилна.

б. "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-аар З болон түүнээс дээш хавтастай, эсхүл З болон түүнээс дээш олон яллагдагч, оролцогчтой хэргийг хуваарилна.

2.2. Давж заалдах хяналтын журмаар хянагдаж анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан ирүүлсэн хэргийг журмын 2.1-д зааснаар тойрог дотор санамсаргүй тохиолдлын зарчмаар дээрх 2 аргаар хуваарилна.

2.3. Анхан шатны шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтэд буцааж дахин шүүхэд ирсэн тохиолдолд хэргийг урьд шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна.

2.4. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хэрэг шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна. Харин тухайн шүүгч ээлжийн амралттай, удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдах, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд бусад шүүгчдэд ердийн журмаар хэрэг хуваарилах аргаар хуваарилна.

2.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэгт холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх шүүгчид шилжүүлнэ.

2.6. Хорихоос өөр төрлийн ял солих шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой ЭХХШТХ-ийн 37.12 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг урьд нь шийдсэн шүүгч шийдвэрлэнэ. Бусад шүүхээр шийдвэрлэгдсэн асуудлыг шүүгч нарт тойрог дотор санамсаргүй тохиолдлын зарчмаар ердийн журмаар хэрэг хуваарилах аргаар хуваарилна.

2.7. Харьяалал тогтоож ирүүлсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хэргийг журмын 2.1-д заасан зарчмаар хуваарилна.

2.8. Ерөнхий шүүгч болон шүүгчийг татгалzan гаргах хүсэлт, ерөнхий шүүгч болон шүүгч өөрөө татгалzan гарах хүсэлтийг хангасан тохиолдолд хэрэг хуваарилагдсан шүүгчийг алгасч нэгдсэн системд тойрог дотор санамсаргүй тохиолдлын зарчмаар ердийн журмаар хэрэг хуваарилах аргаар дараагийн шүүгчид хуваарилна.

Гурав. Зөрчлийн хэрэг хуваарилах

3.1. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн зөрчлийн хэргийг ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, сугалаагаар тогтоосон тойргийн дарааллаар шүүгчид хуваарилна.

3.2. Давж заалдах шатны шүүхээр хянагдаж хүчингүй болж анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан ирүүлсэн зөрчлийн хэргийг тойргийн дарааллаар шүүгчид хуваарилна.

3.3. Шүүгчийг татгалзан гаргах тухай, шүүгч татгалзан гарах тухай хүсэлтийг хангасан тохиолдолд нэгдсэн системд сугалаагаар тогтоосон тойргийн дарааллаар дараагийн шүүгчид хуваарилна.

3.4. Шүүгч өвчтэй, ажлын тав хүртэлх өдрийн хувийн чөлөөтэй, томилолтоор ажиллаж байгаа тохиолдолд зөрчлийн хэрэг хуваарилахгүй.

Дөрөв. Бусад

4.1. Шүүгч ээлжийн амралт эдлэх болон урт хугацаагаар чөлөө авах бусад хүндэтгэн үзэх шалтгаантай /өвчтэй, чөлөөтэй/ тохиолдолд хэргийг шүүгчид хуваарилахгүй.

4.2. Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө хэрэг хуваарилахыг зогсоох, мөн амраад орж ирэх үед тухайн өдөрт нь хэрэг хуваарилна.

4.3. Шүүгч ээлжийн амралттай, хуанлийн 5 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй тохиолдолд шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон үед ажиллагаанд байгаа хэргийг шүүгч наарт шилжүүлэх эсэх асуудлаар шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэргийг шилжүүлсэн тохиолдолд бусад шүүгч наарт хэрэг шүүхэд ирсэн дарааллаар ердийн журмаар хуваарилна. Хэргийг шилжүүлэн авсан шүүгч тухайн шүүгчийн ажиллагаа хийж байсан хэргийг ажилдаа ормогц нь буцаан шилжүүлэн өгч болно. Энэ тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.4. Ерөнхий шүүгчид хэрэг өргөдөл, гомдол, хүсэлтийг дээрх журмаар хуваарилна.

4.5. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг, нэхэмжлэл хуваарилах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал тухай бүрд нь шүүгчдийн зэлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж шийдвэрлэнэ.

4.6. Тамгын газрын дарга Эрүүгийн хэргийн хөдөлгөөний мэдээллийг улирал тутамд шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж байх.

4.7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шүүгч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарган шүүх хуралдааны товыг тогтоодог ба энэ нь шүүн таслах ажиллагаатай салшгүй холбоотой тул шүүх хуралдааны товыг

7 хоног бүрийн пүрэв гарагт мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, ерөнхий шүүгчийн туслах нар нэгтгэн боловсруулж, ерөнхий шүүгч баталж, албажуулах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах тухай журамд зааснаар холбогдох байгууллагад хүргүүлэхийг Тамгын газрын даргад даалгах.

4.8. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор баталсан журмыг нэгдсэн системд тохируулахдаа шүүхийн Тамгын газрын дарга, Хэргийн хөдөлгөөн хариуцсан ажилтан, ерөнхий шүүгчийн туслах нарын хяналтын доор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулахыг үүрэг болгох.

4.9. Энэхүү журмыг Монгол улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар олон нийтэд нээлттэй, шүүхийн цахим хуудсанд байршуулахыг шүүхийн Тамгын газрын даргад даалгах.

Шүүгчдийн зөвлөгөөний 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**ШҮҮХЭД ИРГЭНИЙ ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДХҮҮНИЙГ СУГАЛААГААР ТОМИЛОХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалыг баримтлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 нэгдсэн систем ашиглан энэхүү журмыг удирдлага болгоно.

1.2. Шүүхэд шинээр ирж буй нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хэргийг шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ажлын цагт ИХШХШТ хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлбэрийг шалгаж ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж “Нэхэмжлэл хүлээн авах” бүртгэлд бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

**Хоёр. Хэрэг, нэхэмжлэл хуваарилах**

2.1. Шүүхэд шинээр ирсэн нэхэмжлэл, хэрэг, адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоож ирүүлсэн хэргийг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор “Иргэн-2014” нэгдсэн системээс тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргыг сонгон хуваарилна.

2.2 Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, нэхэмжлэл, хүсэлтийг буцаасан, нэхэмжлэлээ татан авсны дараа уг нэхэмжлэл дахин ирсэн тохиолдолд урьд онд шийдвэрлэснээс үл шалтгаалан өмнө шийдвэрлэсэн шүүгчид гараар хуваарилж, “Иргэн-2024” нэгдсэн системд бүртгэнэ.

2.3. Энэ журмын 2.2-т заасан нэхэмжлэлийг өөр шүүгчид тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилсан нөхцөл байдал иргэний хэрэг үүсгэхээс өмнө мэдэгдвэл системээс гараар өмнө шийдвэр гаргасан шүүгчид буцаан хуваарилах бөгөөд иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд хуваарийг өөрчлөхгүй.

2.4. Хэрэв шүүгч эзлжийн амралттай, сургалтанд хамрагдаж байгаа, удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй зэрэг шалтгааны улмаас түр эзгүй байх үед

нэхэмжлэлийг дахин гаргасан бол уг нэхэмжлэлийг бусад системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

2.5. Журмын 2.4-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсний дараа дахин нэхэмжлэл гаргасан бол анх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчид гараар хуваарилна.

2.6. Давж заалдах, хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэргийг системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

2.7. Шүүгчийг татгалзан гаргах тухай, шүүгч татгалзан гарах тухай хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд хэргийг бусад шүүгчдэд гараар тойроор хуваарилна.

2.8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг тус хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар хүчингүй болгосон тохиолдолд системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

2.9. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас өмнөх шийдвэрийг хүчингүй болгож, ердийн журмаар хянан шийдвэрлэхээр анхан шатны шүүхэд буцаасан тохиолдолд хэргийг тухайн шийдвэрийг гаргасан шүүгчид гараар хуваарилна. Тухайн шүүгч ажиллаагүй тохиолдолд тойроор гаргасан шүүгчийн нэрсийн дарааллын дагуу хуваарилна.

2.10. Иргэний хэргийг тусгаарлах тохиолдолд үндсэн болон тусгаарласан хэргийг аль алиныг нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан шүүгч шийдвэрлэнэ.

2.11. Иргэний хэргийг нэгтгэсэн тохиолдолд хугацааны хувьд эхэлж иргэний хэрэг үүсгэсэн хэрэгтэй нэгтгэн, уг хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй шүүгчид хуваарилна.

#### Гурав. Хүсэлт, гомдол хуваарилах

3.1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, хүсэлтийг тухайн хэрэгт ажиллагаа хийж байгаа шүүгчид гараар хуваарилна.

3.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д заасан хүсэлт буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах тухай хүсэлт, Давж заалдах, Хяналтын журмаар гомдол гаргах хугацаа сэргээлгэх тухай хүсэлт, Давж заалдах, Хяналтын журмаар гомдол гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх, хойшлуулахтай холбоотой

хүсэлтийг тухайн шийдвэрийг гаргасан шүүгчид гараар хуваарилна. Хэрэв тухайн шийдвэрийг гаргасан шүүгч ажиллахгүй болсон бол бусад шүүгчдэд тус тогтоолын 1.1-д заасан нэrsийн дарааллын дагуу тойргоор хуваарилна.

3.3. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой хүсэлтийг системээс гараар тухайн шүүгчид нь хуваарилна. Харин тухайн шүүгч ээлжийн амралттай, удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдах, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд бусад шүүгчдэд гараар тойргоор хуваарилна.

3.4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан хүсэлт буюу шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдол, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг бусад шүүгчдэд гараар тойргоор хуваарилна.

3.5. Шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх, улсын тэмдэгтийн хураамж буцаан гаргуулах тухай хүсэлт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг тойргоор гаргасан нэrsийн дарааллын дагуу системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

3.6. Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээ, гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулах тухай хүсэлтийг Ерөнхий шүүгчээс бусад шүүгчид хуваарилах ба “Иргэн-2014” нэгдсэн системд байрших тойрогт

1. Шүүгч Ц.Энхжаргал

2.Шүүгч Л.Түвшинжаргал гэсэн дарааллаар **системээс тойрог дотор санамсаргүй тохиолдлын** аргаар хуваарилна. Хэрэв шүүгч нар ээлжийн амралттай, сургалтанд хамрагдаж байгаа, захиргааны чөлөөтэй зэрэг шалтгааны улмаас түр эзгүй байх үед Ерөнхий шүүгчид хуваарилна.

3.7. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тухайн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд программд өөрчилсөн үндэслэл, шийдвэрийн талаар шаардагдах өгөгдлүүдийг оруулах бөгөөд энэ талаарх баримтын хувийг программ хангамж хариуцсан ажилтанд хадгалуулж, жил бүр архивд шилжүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг, нэхэмжлэл хуваарилах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал Ерөнхий шүүгч тухай бүр шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж, шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

4.2. Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө хэрэг

хуваарилалтыг зогсоох, мөн амраад орж ирэх үед тухайн өдөрт нь хэрэг хуваарилна,

4.3. Шүүгч ажлын 5 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтанд оролцох болсон тохиолдолд нэхэмжлэл, өргөдөл, гомдол хуваарилахыг зогсооно.

4.4. Шүүгч 1 сараас дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай байгаа тохиолдолд нэхэмжлэл, хэргийг нь бусад шүүгч нарт шилжүүлэх эсэх асуудлаар шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Хэргийг шилжүүлэн авсан шүүгч тухайн шүүгчийн ажиллагаа хийж байсан хэргийг ажилдаа ормогц нь буцаан шилжүүлэн өгч болно. Энэ тохиолдолд шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.5. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор баталсан журмыг нэгдсэн системд тохируулахдаа Шүүхийн Тамгын газрын дарга, хэргийн хөдөлгөөн хариуцсан ажилтан, Ерөнхий шүүгчийн туслах нарын хяналт дор мэдээлэл технологийн мэргэжилтэн тохируулна.